

Living the Lotus 9

Buddhism in Everyday Life

2025
VOL. 240



РКК, Шри Ланка салбар

**Living the Lotus
Vol. 240 (2025.09)**

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын
хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж бодох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Насны намраас өвөлдөө бэлдэх нь

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Явах зүйл яван одож, амьдрал дахин дэлбээлнэ

Амьдралыг дөрвөн улиралтай зүйрлэх нь их. Амь нас соёолж өсөж өндийх үеийг хавар, эрч хүч цалгисан, нийгэмд хийж бүтээх үеийг зун, хүний хувьд боловсорч гүйцэн, үр жимсээ хураан өвөлдөө бэлдэх үеийг намар, амьдралынхаа үр жимсийг хүртэн амар тайван амьдарч, өөрөөс унасан үр хавар соёлохыг хүлээх үеийг өвөлтэй зүйрлэдэг.

Хүн хүн өөрөөр хүлээж авч магадгүй ч, “100 насалдаг үе” гэж хэлж ярих болсон өнөө үеэр аваад үзэх юм бол 25 хүртэлх насыг хавар, 50 хүртэлх насыг зун, 75 хүртэлх насыг намар, түүнээс хойшихыг өвөл гэж хэлэхэд хэлсдэхгүй болов уу.

Энэ дөрвөн улирал дундаа намраас өвөл хүртэлх үеийг эрч хүч багатай, гандсан навчис газар унах, хүйтэн жихүүн улиралыг угтах гунигтай үе гэж төсөөлөх хүн олон.

Гэвч амьдралыг мөн адил дөрөв ангиллаж үздэг эртний Энэтхэгийн “Амьдралын дөрвөн үе шат” гэх үзлээр бол намар үеийг “Бясалгах үе” гэж хэлдэг ба энэ нас нь чухамдаа амьдралын алтан үе бөгөөд элдэв саад бэрхшээлээс ангид, амьдралын сүүлийн үе болох өвөл буюу “Жаргах үе”-ээ амар тайван, жаргалтай өнгөрөөх бэлтгэл хийх үе гэж сургажээ.

“Болох зүйл болоод өнгөрч

Бас дахин намрын тэнгэр цэлмэнэ.” (Ийда Рюүта) хэмээх шүлэг байдаг. Амьдралын намар хүртэл саад бэрхшээл ихтэй байсан бол түүнээс хойш бага багаар тэдгээрээс ангижирч, жинхэнэ хүсэл мөрөөдөл, хийхийг хүссэн зүйлээ хийж, сэтгэл тэнгэр өвлийг угтах үе бол насны намар гэсэн утгатай.

Гэхдээ заримдаа “Тэр үед ингэх л байсан юм” гэж харамсах үе байдаг ба ялангуяа амьдралын сүүл хагаст ийм бодол төрөх нь элбэг. Тэр харуусал, эргэцүүлэл ч гэсэн өвөлтэй золгохын тулд хэрэгтэй “үр жимс” биш гэж үү?

Намрын илжгэн чихний аргуу гашуун, туулайн бөөрний өргөснөөс зугтаад байвал хоол тэжээл болохгүй тул арвин сайхан ургац авлаа гэж бодоод арилгаж янзлаад идвэл сайхан амтыг нь мэдэрнэ. Үүний нэгэн адил гашуун дурсамжаа ч гэсэн “ургац” хэмээн хүлээн авч, түүгээр оюун санаагаа цэнэглэж, өвөлдөө бэлдэх шим тэжээл болгон ашиглах чухал. Энэ нь чухамдаа энэ үед л хураах боломжтой арвин ургац билээ.



Амьдралын өвөл бол сурч мэдэх нас

Эдүгээгээс 2600 орчим жилийн өмнө 74 насандаа таалал төгссөн Күнз «Шүүмжлэл өгүүлэл» номондоо “50 хүрэхүйд тэнгэрийн бошгыг таньж, 60 хүрэхүйд сонссон болгоноо хүлээн авч, 70 хүрэхүйд хүсэл зоргоороо явавч хэв ёсны хүрээ хэвчээнээс хэтэрч эс халив.” хэмээн оюун санааныхаа ахиц дэвшлийг өгүүлсэн байдаг. Насны намар ирэхээр нартын жамыг ухаарч, хүний ярианы цаад утга учрыг ойлгодог болж, өвөл ирэхээр хүсэл санааныхаа зоргоор явсан ч хүн угаас ёс зүй, дүрэм журмыг зөрчихгүй болдог ажээ.

Би одоо ид амьдралынхаа өвлийг туулж яваа ч гэсэн оюун санааны хувьд ийм боловсорч гүйцсэн түвшинд хүрэх болоогүй байна. Гэхдээ тухайн үеийн дундаж наслалтыг бодоод үзэх юм бол Күнзийн 70 нас гэдэг одоогийн 100 настай тэнцэх байх. Тэгэхээр 80 гарсан над мэтийн хувьд сурч мэдсэн нь хангалтгүй, мэдэхгүй ойлгохгүй зүйл олон байгаа тул шулуухан хэлэхэд улам илүү ихийг сурч мэдэх юмсан гэж бодогдож байна.

Хүн бүрт төрөлхийн ийм хүсэл эрмэлзэл байдаг. Түүнчлэн суръя гэсэн сэтгэл л байх юм бол хэд насалсан ч бай шинэ зүйлийг олж хардаг ба тэндээс мэдрэх аз жаргал, сэтгэл хөдлөл нь насны өвлөө жаргалтай өнгөрөөх амьдралын эрч хүчийг өгдөг.

Үүний тулд мэдээж эрүүл мэнд чухал боловч “Нагасакигийн энх тайвны дурсгалт хөшөө”-гөөрөө алдартай уран сийлбэрч Китаamura Сэйбоо гуай хий насаараа 100-тай байхдаа 77 настай Үүсгэн байгуулагчтай уулзах үеэрээ эрүүл саруул урт наслахын нууц бол “Уурлаж бухимдахгүй, жижиг сажиг зүйлд сэтгэлээ чилээхгүй байх” гэж хэлсэн гэдэг. Үүсгэн байгуулагч үүн дээр нэмээд “худал хэлэхгүй байх” гэж хэлтэл тэрбээр “худал хэлэхгүй байснаар сэтгэл угаагдан ариусах тул эрүүл мэндэд нэн тустай” гэж хариу хэлээд, “Сэтгэл цэвэр ариун байваас нас уртасна” хэмээн өдөр тутамдаа санаж явдаг зүйлээ зааж өгсөн гэдэг.

Улам ихийг сурч мэдэхийн төлөө хичээдэг, чимэг зүүлтгүй шулуун шударга зан чанар залуу хойч үед үлгэр дуурайл болох нь дамжиггүй. Тиймээс энэ эрдэм мэдлэгээ гүнзгийрүүлэх тухайд дараагийн дугаарт өгүүлэх болно.


«Косей» сэтгүүл, 9-р сарын дугаараас



Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Рисшо Косей Кай нийгэмлэгийн байгууламж

Оомэгийн сургалтын өргөө ба Үүсгэн байгуулагчийн төрсөн нутгийн номын өргөө



Бяцхан мэдлэг

Үүсгэн байгуулагчийн төрсөн гэрийг 2006 онд түүний мэндэлсний 100 жилийн ойн хүрээнд сэргээн босгосон. Сүганүма тосгонд очихдоо зочлон очиж тухайн үеийн Үүсгэн байгуулагчийн амьдралтай танилцаарай.

Оомэгийн сургалтын байгууламжийг 1966 онд залуу гишүүдийн сургалтын зориулалтаар Токиогийн Оомэ хотын ногоон байгалиар хүрээлэгдсэн өргөн уудам газар байгуулсан. Тэнд хоёр сургалтын байр, хөнгөн атлетикийн болон бейсболын талбай зэрэг бий. Одоо бол бүх гишүүд сургалт семинараар ашиглах боломжтой болсон.

Үүсгэн байгуулагчийн нутгийн номын өргөө нь түүний төрсөн нутаг болох Нийгата мужийн Тоокамачи хотын Сүганүма тосгонд 1978 онд баригдсан ба төрсөн нутгийн мөргөлийн төв болдог. Хажууханд нь төрсөн гэрийг нь сэргээн босгосон байдаг.



Номын өргөө гадаад, дотоодод өргөжин тэлсэн нь



Бяцхан мэдлэг

Судар уншлагын хамгийн эхэнд “Бясалгал үйлдэн гэгээрэх газар” гэж байдаг ба тэр нь гэр бүл, сургууль гээд амьдралын бүхий л талбар өөрөө бурхны үйлд хичээх газар гэж сургадаг. Гэвч үүнийг хэрэгжүүлэх тун хэцүү. Тиймээс л номын өргөөн хэрэгтэй байдаг.



Хүн бүхэн хаана ч, хэзээ ч Цагаан лянхуа судрын сургаалд суралцаасай гэсэн зорилгоор Япон даяар салбар нийгэмлэгүүд, бүс нутгийн номын өргөөг байгуулсан.

Мөн АНУ, Бразил, Их Британи, Тайвань, Тайланд, Шри Ланка, Энэтхэг, Балба, Бангладеш, Солонгос зэрэг улсад салбар бий.

Номын өргөө нь ёслолын үйл ажиллагаа, сургалт семинар, нийтийн цуглаан хийх газар болоод зогсохгүй зовлон бэрхшээлээ шийдвэрлэх газар ч болдог. Тиймээс амин өдөр хийгээд амралтын өдрөөр нийгэмлэгийнхээ бурханд мөргөхөөр очиж байгаарай.

Амьдралын үе шатаас суралцаж,
сэтгэл хангалуун амьдрахуй

Акагава Кэйичи

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Японд эртнээс "Зуны халуун ч, өвлийн хүйтэн ч хиган хүртэл." гэж хэлж ярьцгааж ирсэн. Одоогоор зуны сүүлийн халуун өдрүүд үргэлжилсээр байгаа ч хааяа нэг хацар илбэх сэрүүн салхи удахгүй ирэх улирлын өөрчлөлтийг мэдрүүлнэ. Та бүхэн эрүүл саруул, амгалан суугаа гэж найдаж байна.

Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвартаа хүний амьдралыг дөрвөн улиралтай зүйрлэн нэг насны амьдралыг дөрвөн үед хувааж сэтгэл хангалуун, баяр баясгалантай амьдрах талаар өгүүлдэг эртний Энэтхэгийн "Амьдралын дөрвөн үе шат" хэмээх сургаалыг танилцуулсан. Би энэ амьдралын философитой 40 гаруй насандаа Ицүки Хироюкигийн "Амьдралын намар буюу бясалгах үе" гэх номоор дамжуулан анх учирсан. Амьдралыг сурч боловсрох нас, гэр бүл зохиох нас, бясалгах нас, жаргах нас гэсэн дөрвөн үед хуваан, үе бүрт тохирсон амьдралын хэв маягийг заадаг энэ сургаалыг орчин цагийн нийгэмд тэр чигээр нь хэрэгжүүлэх нь бие махбод, эдийн засгийн хувьд хүндрэлтэй л юм гэж бодохын сацуу "Оюун санааны амьдралын дөрвөн үе шат" байдлаар хэрэгжүүлбэл байж болох юм гэж тухайн үед бодож билээ. Хэрэв үнэхээр ингэж амьдрах боломжтой бол хүн сэтгэлийн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх биз ээ.

Ерөнхийлөгч хүний амьдралын намар буюу бясалгах үеийг "Энэ үе хүртэл саад бэрхшээл ихтэй байсан бол түүнээс хойш бага багаар суларч, жинхэнэ хүсэл мөрөөдөл, хийхийг хүссэн зүйлээ хийж, сэтгэл тэнэгэр өвлийг угтах үе бол намар" гэж тайлбарласан. Хавар, зун, намар, өвлийн алинд нь ч ховор үнэ цэнтэй үр жимс байдаг шиг дутуугийн сэтгэлээс болж итгэл бишрэлээ алдалгүй байхад хичээж, "Өнөөдөр бол өнгөрсний үр дүн бөгөөд өнөөдөр ирээдүйг бүтээдэг" гэх үнэнийг санаж, энэ сард ч мөн даруу төлөв зан, талархсан сэтгэлээр шамдан суралцах болно.

Хиган: Хавраас зунд шилжих, зунаас намарт шилжих өдөр




8 сарын 2-нд удирдах төвд зохион байгуулагдсан "Зүүн Азийн лидерийн сургалт"-нд оролцсон Солонгос, Монголын гишүүдийн хамт. Энэ жил Тайнан салбар ч оролцсон ба эхний гурван удаагийн сургалт цахимаар дөрөв дэх нь ийнхүү удирдах төвд болсон.

Rissho Kosei-kai International


Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp